

**Монгол уртын дууны бүс нутгийн уран сайхны шинж чанарын судалгаа
(Өвөр Монголын барга буриад, цахар үзэмчний баримтуудаар)**

*Ш.ӨЛЗИЙБАЯР**

*Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Хөх хот,
Өвөр Монголын Их Сургууль,
Email: oljeibayar@gmail.com*

*Ө.УНДРАА***

*Бүгд Найрамдах Хятад Ард Улс,
Ху бэй муж, Ү хань хот,
Төв Хятадын Багийн Их Сургууль
Email: 517253744@qq.com*

Received: December 01, 2025 | **Accepted:** December 20, 2025 | **Published:** December 30, 2025

Хураангуй: БНХАУ-ын ӨМӨЗО-ын монгол уртын дууны судлал хөгжиж ирсэн боловч овог аймгийн айд ая аялгууны уран сайхны шинж чанарыг гүнзгийрүүлэн судалсан бүтээл олон харагдахгүй байна. Тус өгүүлэлд барга, буриад болон үзэмчин, цахрын уртын дууны уран сайхны шинж чанарыг харьцуулан судалсан үр дүнг танилцуулав. Энэ нь монгол уртын дуу, цаашилбал монгол судлалд шинжлэх ухааны чухал ач холбогдол өгөх юм. Судалгааны арга зүйн хувьд, дорно дахины таван эшигт хөгжмийн онолд үндэслэн, үндэстний дуу хөгжмийн бүртгэл судалгааны аргыг ашиглан, эдгээр уртын дууны хөгийн цомнол, хөгийн чанарын үндсэн шинж, өгүүлбэрийн төгсгөлийн эшиг, өгүүлбэрийн төгсгөлийн уртатгал, аялгууны хэв намба, дуулах арга барилын шинж чанар гэх мэт хэвшмэл мөн чанарт дүн шинжилгээ хийснээрээ шинэлэг талтай.

Түлхүүр үг: Өвөр Монгол, Барга, Буриад, Цахар Үзэмчин, Уртын дуу, Уран сайхны шинж чанар, Дуулах хэв маяг

* © Ш.Өлзийбаяр, 2025; * - Холбоо барих зохиогч

** © Ө.Ундраа, 2025

A Study on the Artistic Characteristics of Mongolian Folk Song Regional Styles

(Based on Materials from barga buryat and chakhar, uzemchin in Inner Mongolia)

WULJIBAYAER, SH
Inner Mongolia University,
Hohhot, China

WENDULA, U
Central China Normal University,
Hu bei, Wuhan city, China

Abstract: While the study of Mongolian folk songs (Urtyn duu) has progressed significantly in Inner Mongolia, there remains a lack of thorough research evaluating the creative characteristics of clan and tribal melodic styles. This research aims to conduct a comparative examination of the artistic attributes in the folk songs of the Barga-Buryat and Uzemchin-Chakhar.

The findings have significant scientific implications for the study of Mongolian folk songs and broader Mongolian studies. This study employs a fresh methodological framework to examine the Five Pentatonic Modes Theory of the Orient as well as ethnomusicological recording methodologies. It examines established attributes such as melodic structure patterns, critical aspects of melodic quality, important sections of phrase-final vowels, essential features of phrase lengthening strategies, key elements of melodic conventions, and major segments of professional singing styles.

Keywords: Inner Mongolia, Barag Buryat, Chakhar Uzemchin, folk song artistic features, vocal style.

Удиртгал

Монголын олон овог аймаг өргөн уудам хээр тал, ой хөвч, говь нутагт нэгэн үндэстний нэгдмэл цогцоор хэдэн мянган жилээр тархан амьдарч ирэхдээ нүүдлийн аж ахуй, ан гөрөө, газар тариалан, хот суурин, үйлдвэр худалдаа гэх мэт баялаг сайхан соёлыг үүдэн бүтээж, өвлөн уламжилж иржээ. Хэдэн арван мянгаар тоологдох монгол ардын дуу нь түүний нэгэн тод жишээ билээ. Хэзээ, хаана ч давтагдашгүй үндэстний нийтлэг шинжтэй монгол уртын дуу нь монгол соёлын доторх онцгой содон урлаг юм. Түүнчлэн халх, ойрад, барга, буриад, үзэмчин, цахар (Урдын Цахар түмний харьяанд байсан өнөөгийн Шилийн голын дөрвөн цахар хошуу, Улаанцавын гурван цахар хошууг хамарна), хорчин Баарин... гэх мэт монгол угсаатны бүлгийн уртын дуу нь үндэстний нийтлэг шинжтэй хэдий ч өөр хоорондоо харилцан адилгүй шинжтэй. Энэ нь ихэвчлэн уран сайхны шинж чанараараа ялгарна.

Дуу хөгжмийн уран сайхны шинж чанар нь түүний хэвшмэл шинжээр илэрдэг. Голдуу аялгууны эцэс, хөгжмийн өгүүлбэрийн төгсгөл эгшиг болон өгүүлбэрийн эцсийн уртатгал зэрэг чухал хүчин зүйлээс бүрддэг. Аялгууны төгсгөлийн аяс бол ердөө хөгийн цомнол (хөгийн хэв)-ыг тогтоодог “эзэн” ая байдаг. Ямар нэгэн үндэстний дуу хөгжмийн айд харьяалагдах бүтээлийн төгсгөлийн аяыг бүртгэн

судалбал, түүний хөгийн нийтлэг болон хэв шинжийг бүхэлд нь ойлгож болно.

Хөгжмийн өгүүлбэрийн төгсгөлийн ая бол түүнээс өмнөх аялгууны үр дүн мөн. Эхний аялгуу дахь хувирал хойнох аялгуундаа зайлшгүй нөлөөлдөг. Тиймээс ямар нэгэн аялгуунд хөгжмийн өгүүлбэрүүдийн төгсгөлийн ая нь тухайн аялгууны үндсэн байдлыг тогтооно. Өгүүлбэрийн эцсийн уртасгал бол онцгой хэсэг юм. Өгүүлбэрийн эхэн ба дундах ая үгийн онцлогоос хамаарч олон янзаар хувирдаг байхад, өгүүлбэрийн эцсийн уртатгал ая харьцангуй тогтвортой байдаг онцлогтой.

Алив нэг үндсэн чанартай өгүүлбэрийн эцсийн уртатгал ая нь аялгууны хэв шинжийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй төдийгүй ямар төрлийн дуу хөгжмийн аялгууны онцлогийг тодруулах чухал бэлгэ тэмдэг болдог. Эдгээр онцлог зүйлсийн бүрдэл судалгаа монгол дууны судалгаанд бараг нэвтрээгүй тул тус өгүүлэлд судалгааны шинэ өнцөг болж буй. Тиймээс бид, барга буриад болон үзэмчин, цахрын арван хошууны уртын дууны уран сайхны шинж чанарт дүн шинжилгээ хийж, эдгээр хүчин зүйлсийг харьцуулан судлахыг хичээв.

Нэг. Хөгийн цомнолын үндсэн шинж чанар

Өвөр Монголын барга, буриад болон цахар, үзэмчин уртын дуу бол ая дууны манлай гэж хослон яригддаг. Бид, энэхүү хоёр бүлэгт хуваасан угсаатны уртын дууны уран сайхан чанарыг юуны өмнө хөгийн цомнол, хөгийн чанарын хэвшмэл шинжийн талаас судлан үзэж байна. Тэгэхдээ Хятад улсын албаны хэвлэлийн хороонуудаас хэвлэн тараасан монгол ардын дууны эмхэтгэл түүврүүдийн дотроос төлөөлөх чанартай

а) Барга, буриадын уртын дуунаас 37,

б) Цахар, үзэмчний уртын дуунаас 47-ийг тус тус сонгон авч бүртгэл судалгааны аргаар хөгийн цомнол ба хөгийн шинж чанарт шинжилгээ хийж нэгтгэн дүгнэв.

1. Баримтуудын хөгийн цомнолын тархац

Хүснэгт 1. Барга, буриад, цахар, үзэмчний уртын дууны хөгийн цомнолын бүтэц

№	Дууны нэр	Дууны төрөл	Хөгийн цомнол ¹
1	Хөвчин өндөр уул	Барга, буриад уртын дуу	Юудуун

¹ Дууны эгшгийг нэрлэх уламжлалт нэршил (Нэршлүүд толь бичиг болон хөгжмийн бүтээлүүдэд харилцан адилгүй хэлбэрээр бичигдсэн байдаг тул зохиогчдын бичсэнийг хөндсөнгүй). Тайлбарыг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”(2006)-иос үзнэ үү. Я.Цэвэлийн (1966) “Монгол хэлний товч тайлбар толь”-д гундагуун-гундуун, гидагуун-гидуун, жидагуун-жидуун, юдагуун-юудуун гэдгийг тайлбарласан байдаг нь монголчуудын таван эгшигтийн зарчим бөгөөд угсаатны хөгжим судлаач Ж.Бадраа (2005) “жидагун-идэт дуун, гүндэгүн-хүнгэнэх дуун, шандагун-цангинах дуун, юдагун-жингэнэх дуун, гиюдагун-гингэнэх (цуурын дуу)” хэмээжээ. Эдгээр аялгыг нийт 12 хөг гээд арга, билигт хуваадаг. Хөгжим судлаач З.Соронзонболд (2013) “Монгол хөгжим: Юань улсын ордны хөгжим, бүжиг, жүжиг, хувцас” бүтээлдээ “Арга билиг эгшгийн алиныг нь хувиргасныг үзвэл,

2	Богд уулын сэндэр	Барга, буриад уртын дуу	Юудуун
3	Баян баргын манаа	Барга, буриад уртын дуу	Юудуун
4	Алтай хангай	Барга, буриад уртын дуу	Юудуун
5	Жаран цагаан тэмээ	Барга, буриад уртын дуу	Юудуун
6	Гархилаад урсах хандгайн гол	Барга, буриад уртын дуу	Юудуун
7	Саруул тал	Барга, буриад уртын дуу	Юудуун
8	Цагаан толгойн орой	Барга, буриад уртын дуу	Юудуун
9	Ягаан улаан	Барга, буриад уртын дуу	Юудуун
10	Соёг бор	Барга, буриад уртын дуу	Юудуун
11	Мөнтгөр саарал	Барга, буриад уртын дуу	Юудуун
12	Цагаан саарал	Барга, буриад уртын дуу	Юудуун
13	Ганжи нуур	Барга, буриад уртын дуу	Юудуун
14	Мэлмэрсэн нулимс	Барга, буриад уртын дуу	Юудуун
15	Шил дээгүүр будантай	Барга, буриад уртын дуу	Юудуун
16	Хошуу шил	Барга, буриад уртын дуу	Юудуун
17	Баян тунгалаг	Барга, буриад уртын дуу	Юудуун
18	Нарийхан халиун	Барга, буриад уртын дуу	Юудуун
19	Эрдэнэ уулын бараа	Барга, буриад уртын дуу	Гундуун
20	Хөлөн буйр нутаг	Барга, буриад уртын дуу	Гундуун
21	Дүүлгэр хүрэн	Барга, буриад уртын дуу	Гундуун
22	Оонын хоёр эвэр	Барга, буриад уртын дуу	Гундуун
23	Энтэй хүрэн шанхай	Барга, буриад уртын дуу	Гундуун
24	Галуун хүзүү зээрд	Барга, буриад уртын дуу	Гундуун
25	Замбуулин хорвоо ертөнц	Барга, буриад уртын дуу	Гундуун
26	Намрын тунгалаг огторгуй	Барга, буриад уртын дуу	Гундуун
27	Хөнтөргөн хээр	Барга, буриад уртын дуу	Жидуун
28	Алтан гургалдай жигүүртэн	Барга, буриад уртын дуу	Жидуун
29	Жарны үүд	Барга, буриад уртын дуу	Жидуун
30	Өвдөгийн арын рашаан	Барга, буриад уртын дуу	Жидуун
31	Хар хээрийн гоёлол	Барга, буриад уртын дуу	Жидуун
32	Алсын бараа	Барга, буриад уртын дуу	Жидуун
33	Бүжинхэн туулай	Барга, буриад уртын дуу	Жидуун
34	Эр бор харцага	Барга, буриад уртын дуу	Шандуун
35	Сумъяагийн цэцэг	Барга, буриад уртын дуу	Шандуун
36	Наран тунгалаг	Барга, буриад уртын дуу	Шандуун


37	Хэрээтэйхэн хээр	Барга, буриад уртын дуу	Гиодуун
----	------------------	-------------------------	---------

Цахар, Үзэмчин уртын дууны хөгийн цомнолын бүртгэл

№	Дууны нэр	Дууны төрөл	Хөгийн цомнол
1	Сэрүүн сайхан хангай	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
2	Богд Чингис	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
3	Жаа мөрний ус	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
4	Баян цагаан алтан дэлхий	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
5	Чивчгэр бор	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
6	Дүүрэн заан	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
7	Булган тохой	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
8	Цагаан тохой нутаг	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
9	Хөвчийн саглагар мод	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
10	Хүжийн утаа	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
11	Сайхан жантай	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
12	Нарийн хөх	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
13	Хонгор халиун	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
14	Булган хангай	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
15	Богдын өндөр	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
16	Хөдөө шил	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
17	Өвгөн шувуу	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
18	Жорооны жороо	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
19	Өнчин цагаан ботго	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
20	Өлийн даваа	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
21	Зээргэнэтийн шил	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
22	Манд толгой	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
23	Ганган хар	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
24	Үүр сүүлт	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
25	Урьхан хонгор	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
26	Гишгэдэл сайт	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
27	Янзган зоотой саарал	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
28	Жаахан шарга	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
29	Хүдэр хүрэн	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
30	Согоо бор	Цахар, үзэмчний уртын дуу	Юудуун
31	Будал цолмон	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун
32	Алтан жигүүртэй цэгцүүхэй	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун

33	Намаг тал	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун
34	Зулзаган хонгор	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун
35	Ар хөвч	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун
36	Хөх бор	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун
37	Дөрвөн настай халиун	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун
38	Толботой бор	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун
39	Цомбон туурайтай хүрэн	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун
40	Амгалант төрийн товчоо	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун
41	Хан уул	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун
42	Дөрвөн цаг	Цахар, үзэмчний уртын дуу	Жидуун
43	Жаа мөрний цэцэг	Цахар, үзэмчний уртын дуу	Шандуун
44	Тунгалаг гэгээн	Цахар, үзэмчний уртын дуу	Шандуун
45	Эртийн цагаан буян	Цахар, үзэмчний уртын дуу	Шандуун
46	Сэрмүүн сайхан сэлж	Цахар, үзэмчний уртын дуу	Гундуун
47	Бөхийн урилга	Цахар, үзэмчний уртын дуу	Гундуун

1. Барга Буриад уртын дууны цомнолын бүртгэл



2. Баримтуудын хөгийн цомнолын тоон үзүүлэлт, үндсэн шинж


а) Барга, буриадын уртын дуу

Бүртгэл судалгааны дүнгээс Барга, буриадын уртын дуу нь таван эгшигт хөгийн цомнолоор зохиогдож хөг нь ихээс бага руу буюу юудуун, гундуун, жидуун, шандуун, гидуун (гиодуун) гэх цомнолтой байна. Түүнд юудуун цомнолтой 18 дуу байх бөгөөд тэр нь 48.65% буюу бараг хагас хувийг эзэлж байгаа бол гундуун цомнолтой дуу 8, жидуун цомнолтой дуу 7 буюу тус тус 21.62%, 18.92% хувийг, шандуун цомнолтой дуу 3 орж, 8.11%-г эзэлж байна. Гиодуун цомнолтой дуу ганцхан буюу 2.70% хувийг эзэлсэн нь ховор тохиолдол болжээ. Үүнээс барга, буриадын уртын дуу голцуу юудуун цомнолтой гэж болох бөгөөд гундуун ба жидуун цомнолтой дуу нийлээд хагас орчим хувийг эзэлж байхад шандуун болон гиодуун цомнолтой дуу тун цөөн байгааг харж болно.

Барга, буриадын уртын дууны бодит байдлыг ажиглахад хөгийн хувиралт нэлээд хэвшмэл, заавал солих шаардлагатай үед нэг ижил гүний системд хөг сэлгэж, аялгуу эгшгээ дэлгэрүүлэн өрнүүлдэг байна. Тус бүс нутгийн хөг шилжилт ихэнхдээ доошилсон харьяат гүний системийн олон хэлбэрээр баялаг хувирдаг. Доор харьяат гүн системийн олон хөгт шилжих, доор харьяат ижил төрлийн хөгийн томьёонд шилжих, харьяат хөгөөс эхэлж гол хөг дээр төгсгөх, ойр харьцаат хөг займралыг хийх гэх мэтийн аргыг нэлээд түгээмэл, хэвшмэл хэрэглэдэг ажээ.

б) Цахар, үзэмчний уртын дуунд

2. Цахар Үзэмчний уртын дууны цомнолын бүртгэл



Харьцуулалтаас цахар, үзэмчний уртын дуу нь аялгууны хувьд ихээс бага руу буюу юудуун, жидуун, шандуун, гиодуун гэх мэтээр жагсаагдах бөгөөд Барга, буриадын уртын дуунд хоёрдугаар байранд байсан жидуун цомнол энэ үзүүлэлтээр дөрөвдүгээр байранд, гуравдугаарт байсан жидуун цомнолын байр нэг урагш, шандуун цомнолтой дууны хувьд ижил байранд оржээ. Харин гиодуун цомнолтой уртын дуу байхгүй байна (Энэ бол зөвхөн бүртгэл судалгаанд сонгогдсон дуунд хандаж хэлсэн үг). Хувиар өгүүлбэл, Үзэмчин, цахар уртын дуунд юудуун цомнолтой дуу 30 буюу 63.83% байгаа нь

нийт дууны тэн хагасаас илүү хувийг эзэлж байна. Жидуун цомнолтой 12 дуу буюу 25.53%, (дөрөвний нэг), шандуун цомнолтой дуу 3 буюу 6.38% байгаа нь Барга, буриадын уртын дуунаас нэлээд цөөн байна. Гундуун цомнолтой дуу 2 буюу 4.26% байгаа нь Барга, буриадын уртын дуутай ижил үзүүлэлт бөгөөд гиодуун цомнолтой дуу таарсангүй.

Үүнээс Барга, буриад уртын дуунд юудуун, гүдуун, жидуун хэмээх гурван зүйлийн аялгуу гол цомнол болж, Үзэмчин, цахар уртын дуунд юудуун, жидуун гол цомнол болж, шандуун, гундуун аялгуутай дуу цөөн байна. Үүнээс цэвэр тод, уянгалаг зөөлөн юудуун цомнол нь дээр өгүүлсэн хоёр нутгийн уртын дуу, улмаар Монголын дуу хөгжмийн хөг аялгууны нийтлэг шинж болж байгааг мэдэж болно. Энэ тухай эрдэмтэн Лю Хун Жиу “Монгол үндэстний ардын дуунд юудуун цомнолтой нь хамгаас олон байдаг” (Лю Хун Жиу, 1981: 17) гэж бичсэн нь онож хэлсэн ажээ.

Үзэмчин, цахар уртын дууны бодит байдлыг ажиглахад хөгийн чанарын хувирал баялаг болох нь ажиглагдав. Ойр ба хол харьцаатай, харьяат гүний системийн хөг, доор харьяат гүний системийн хөг зэрэг олон зүйлийн харьцаагаар хөг шилжилт хийдэг. Гүн эгшгийн харьцаагаар дээш, доошоо их 2 градусуар өгсөж уруудах нь үзэмчин, цахар уртын дууны хамгийн нийтлэг хөгийн чанарын хувиралтын хэлбэр мөн. Иймэрхүү байршуулалтын аргыг “цоорын дуу”-нд хамгийн олон хэрэглэдэг. Бас гол хөгийн тойронд харьяат гүний системийн олон хөгийн хэлбэрээр займран, хөг сэлгэж, аялгууг дэлгэрүүлэн, эмжээрлэж чимэглэдэг. Ойр харьцаат хөг займралын улмаар хол харьцаат хөгийн чанарт бага багаар дамжин хүрээд дахин угийн хөгтөө буцаж ирдэг нь эрт урдын эгэл чанартай “боржигин хөг”-ийн уламжлал юм (Өлзийбаяр, 2008: 43).

Ер нь Цахар, үзэмчний уртын дуу агуулга, хэлбэрийн хувьд бүх талаар боловсрон хөгжиж Хятад дахь монголчуудын уртын дууны ноён оргил, сонгодог хэлбэр нь болсон юм. Учир нь Юань улсын нийслэл цахрын нутагт байж, Монголын улс төр, аж ахуй, соёлын төв болж байсан тул Монгол туургатны нутаг нутгийн шилдэг дуучид энд хуран цугларч, өөр хоорондоо нийлэн уусалцаж, яваа яваандаа уртын дууны бүхий л гайхамшигийг энэ нутагт хамтаар цогцлоож, монгол дуулахуй урлагийн өндөр хэмжээнд хүрчээ. Хөг аялгуу яруу, уртагтал эгшиг гоёмсог, сүр жавхаатай, ханагар уудам, хэм айзам тэгш, ая тэнүүн, зохиомж бүтэц том, утга агуулга гүн гүнзгий, аялгуу эгшгийн хэлбэр, дуулахуй ур эрдэм гээд аль

ч талаараа шинэ түвшинд хөгжин боловсорчээ.

Цахар, шилийн голын монголчууд удаан жилийн түүхтэй уртын дууныхаа өвийг уламжлалт хэлбэр, бүтэц, дуулах хэв намбыг баримтлан, тэдгээрийг өвлөн хадгалж, хайрлан хамгаалж уламжилж ирсэн байна. Монгол уртын дууны сонгодог дуулах хэлбэр “цоорын дуу”, хөгжим дууны хосмолжин хэлбэр “Асар”, алдарт “боржигин аялгуу” гэх мэтийн хааны ордны дуу хөгжмийн шилдэг өвийг бидний үед авчирсан төдийгүй, найман зуун жилийн тэртээх Юань улсын үед говийн өмнөх дундад бүс нутгаар дэлгэрч байсан монгол уртын дууны язгуур хэв маягийг боловсруулан хадгалсаар иржээ.

3. Баримтуудын ижил ба ялгаат чанар

Ижил талууд: Монгол дууны нийтлэг үндэс суурь

А. Юудуун аялгууны үндсэн гол байр суурь: Дурдан бус хоёр бүс нутгийн уртын дуунд юудуун аялгуун голлож байгаа нь уртын дууны гүн гүнзгий, уужим гоо зүйн нийтлэг үндэс, монгол үндэстний дуу урлагийн гол онцлог болж байна.

Б. Жидуун аялгууны туслах үүрэг: Жидуун цомнол нь жишээлж буй хоёр бүс нутгийн уртын дууны аялгууны хоёрдугаарт орж байгаа бөгөөд юудуун цомнолд тулгуурласан, бүдэг өнгөт аялгуунуудад шаардлагатай гэрэл, дулаан буюу амьд шинж чанарыг нэмж, тэнцвэржүүлэх, тохируулах чухал үүрэг гүйцэтгэдэг.

В. Шандуун ба Гиодуун аялгууны байр суурь: Шандуун аялгууны эзлэх хувь энэ хоёр нутагт бага байна. Баримтаар маш ховор (Баргад ганц) эсвэл огт алга (Цахарт). Энэ нь уламжлалт дуунд гиодуун цомнол тогтворгүй байдагтай нийцэж байгаа хэрэг. Ялангуяа энэ хоёр нутгийн гоо зүйн үндсэн үзэл баримтлалд энэ аялгууг төдийлөн ашигладаггүйг харуулж байна.

Ялгаатай талууд: Орон нутгийн гоо зүйн хэв маягууд (divergence)-ын ялгаа

Тоон үзүүлэлтүүдээс харахад энэ хоёр том бүс нутаг аялгын цомнол (аялгуу) ашиглах талаар урлаг, гоо зүйн өөр өөр замналтай нь тодорхой бөгөөд үүний ард тэдгээрийн хөгжмийн хэв маяг, гоо зүйн эрмэлзлийн ялгаа илэрч байна. Ерөнхийлбөл, Барга, буриад болон цахар, үзэмчний уртын дуунууд юудуун, жидуун аялгуу голлож монгол дуу хөгжмийн генийг агуулдаг ч бусад аялгуу, ялангуяа гундуун аялгууг өөр өөрөөр ашигласнаараа урлагийн ялгаатай хэв маягийг бүрдүүлжээ. Барга, буриадын уртын дуу нь олон өнгөт палитр шиг баялаг, тал нутгийн түүхийг хүүрнэх мэт, гүн сэтгэмжит намуун хөг шивнээ, сүрлэг сайхан магтаал аль алиныг агуулдаг. Цахар, үзэмчний уртын дуу нь бодож бясалгах мэт, сэтгэлийн гүний өнгө байдлыг илэрхийлэхэд голлох мэт. Энэхүү ялгаа нь зөвхөн хөгжим судлалын үзэгдэл төдийгүй, орон нутгийн соёл, түүхэн уламжлал, газар зүйн орчин, хөгжмийн гоо зүйд хэрхэн нөлөөлж, тусгалаа олсны илрэл юм.

Хоёр. Өгүүлбэрийн төгсгөлийн эгшгийн үндсэн шинж чанар

Өмнөх агуулгаас бид барга, буриад, сахар, үзэмчний уртын дууны хөг аялгууны хэвшмэл шинжийн нэгдүгээр хүчин зүйл бол аялгууны төгсгөлийн аялгуугаар голчлон илэрдэг хөгийн цомнолын үндсэн байдал, ялгаатай ба төстэй талуудыг үндсэнд нь баримжаалсан гэж үзвэл, удаах хүчин зүйл нь өгүүлбэрийн төгсгөлийн аялгуу болно.

Бидний хийсэн судалгааны дүнд эдгээр бүсийн уртын дууны нийтлэг чанартай аялгууны болон бүхэл цогцын үндсэн байдлыг ямар нэгэн хэмжээнд таниулах боломжтой байна. Тиймээс хөгжмийн өгүүлбэрийн сүүлийн аялгууны тоо хэмжээ, олон цөөн, дэс дарааллыг дараах байдлаар гаргав.

1. Барга, буриадын уртын дууны хөгжмийн өгүүлбэрийн төгсгөлийн эгшиг олноос цөөн рүү, ля (33%), ре (29%), соль (21%), ми (10%), до (7%) гэсэн дэс дараалал, хувь хэмжээтэй байна.

2. Сахар, үзэмчний уртын дууны хөгжмийн өгүүлбэрийн төгсгөлийн эгшигийн хувьд мөн олноос цөөн рүү ля (34%), соль (26%), ре (16%), ми (13%), до (11%) гэсэн дараалалтай байна.

Хөгжмийн өгүүлбэрийн төгсгөлийн эгшиг нь өмнөх аялгууны үр дүн, хувилбарлах байдал нь өдий төдий аяны ч хувирлын үр дүн мөн. Иймд ямар нэгэн дууны хөгжмийн өгүүлбэрийн сүүлийн эгшиг нь бүхэл бүтэн аялгууны үндсэн бүтцийг эрхшээн зохиомжлох зангилаа төдийгүй уг аялгууны үндсэн эгшиг болдог. Тэгэхлээрээ дээрх судалгааны дүнд үндэслэвэл, Барга, буриадын уртын дууны өгүүлбэрийн эцэст “ля”, “ре” хоёр эгшиг байнга тохиолдож байгаа нь бүс нутгийн уртын дууны аялгууны үндсэн онцлог, зохиомж, бүтцийн харьцангуй тогтвортой шинжийг илрүүлэх хөгийн хэлбэрийн үндсэн эгшиг ажээ. Тэгвэл сахар, үзэмчний уртын дууны өгүүлбэрийн эцэст “ля”, “соль” хоёр эгшиг байнга тохиолдож байгаа нь уртын дууных нь аялгууны үндсэн онцлог, зохиомж бүтцийн харьцангуй тогтвортой шинжийг илрүүлэх хөгийн хэлбэрийн үндсэн эгшиг болж байна. Ийнхүү хоёр бүс, угсаатны уртын дууны аялгуу нарийн ялгамжаатай байдгийг харуулж байна.

Гурав. Өгүүлбэрийн төгсгөлийн уртасгалын үндсэн шинж чанар

Барга, буриад ба сахар, үзэмчний уртын дууны хөг аялгууны хэвшмэл шинжид хийсэн судалгаанаас нийтлэг ба ялгаатай тал, аялгууны үндсэн шинж байдлыг ямар нэгэн хэмжээнд ойлгосон гэж үзвэл, гурав дахь хүчин зүйл нь өгүүлбэрийн эцсийн уртатгал ая болно. Бидний тооцооллоор энэхүү хоёр бүлгийн уртын дууны харьцангуй тогтвортой чанар болон хөг аялгууны онцлогийг дараах байдлаар авч үзлээ.

1. Барга, буриадын уртын дууны өгүүлбэрийн төгсгөлийн уртатгал аясын үндсэн шинж чанар

Тооцоогоор барга, буриадын уртын дууны өгүүлбэрийн төгсгөлийн уртатгал аяын таван зүйлийн хэлбэрийг олноос цөөн рүү ажиглахад ре до ля (9%), ля до соль (5%), ля соль ми (4%), ми ре до (3%), соль ля соль (1%) гэх дэс дараалал, үзүүлэлт гарав.

2. Сахар, үзэмчний уртын дууны өгүүлбэрийн төгсгөл уртатгалын үндсэн шинж чанар

Цахар, үзэмчний уртын дууны өгүүлбэрийн төгсгөлийн уртатгал аяын таван зүйлийн хэлбэрийг олноос цөөн рүү тооцоолбол ре до ля (13%), ля соль ми (7%), ля до соль (5%), ми ре до (4%), соль ля соль (3%) гэх дэс дараалал, хувь хэмжээ гарч байна.

Дуу хөгжмийн бүтээлийн өгүүлбэрийн төгсгөлийн уртатгал ая бол өвөрмөц онцлогтой аялгууны хэсэг мөн. Учир нь өгүүлбэрийн эхэн болон дундах аялгуу нь ямагт үг, хэллэгээс шалтгаалан олон янзаар хувирдаг бол өгүүлбэрийн эцсийн уртатгал аяс нь үг үсэгт баригдахгүй, харьцангуй тогтвортой байдаг. Тиймээс дээрх бүртгэлд үндэслэвэл, “ре до ля” болон “ля до соль” хэлбэрт өгүүлбэрийн төгсгөлийн уртатгал аясын нийтлэг шинж нь барга, буриадын уртын дууны аялгууны намбыг бүрэлдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэн, тухайн бүсийн уртын дууны бэлгэ тэмдэг болж байна. Мөн “ре до ля” болон “ля соль ми” хэлбэрт өгүүлбэрийн төгсгөлийн уртатгал аяын нийтлэг шинж нь цахар, үзэмчний уртын дууны аялгууны хэв шинжийг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй, гол өнгө нь болж байдгаараа тус тусын угсаатны бүлгийн уртын дууны харьцангуй тогтвортой хэв намба, хөг аялгууны онцлогийг илтгэж байна гэж үзлээ.

Дөрөв. Аялгууны хэв намбын үндсэн шинж чанар

1. Барга, Буриадын уртын дууны аялгууны хэв намбын шинж чанар

Барга буриадын уртын дуу нь ерөнхий шинжийн хувьд голцуу өндөр аялгуунд уртасгаж дуулах, үндсэн аясыг сунгаж үсрэлт ихтэй уруудуулах, хоолойн нугалааны ур мэргэжлийг өргөн хэрэглэх зэрэг хүчин зүйлээс бүрддэг. Илэрхийлэх байдлыг авч үзвэл,

Өндөр өнгөнд үндсэн аясыг энгийн бөгөөд хүрээлэн чимэглэж уртатгах ба аялгуу эгшиг хангинам чөлөөтэй, илэрхийлэл ил “цайлган” маягтай. “Өндөр аясын цараас аяндаа уруудаж, сэтгэл догдлоом эгшиглэж байдаг. Энэ талаар Цахар, үзэмчнийхний нам эгшгийн цараас эхэлдэг аялгууны намбатай яг эсрэг” (Өлзийбаяр, 2011: 360). Дээд өгүүлбэрийг өндөр өнгөнд, доод өгүүлбэрийг нам өнгөнд тус тус дуулж, өгүүлбэрийн хоорондох харьцаа холбоог өндрөөс нам руу тэгш хэмлэг хийнэ. Өндөр өнгөнд наймцаар нугалж аялгуу эгшгийг дэлгэрүүлэн, оргилуун сэтгэлгээнээс эвлэг хэв шинжид шилжүүлэх ба дөрөвцөөр өгсүүлсэн хувиргалтыг тууштай хэрэгжүүлдгээрээ цахар, үзэмчний уртын дуунд шатлан өгсүүлэх онцлог хурц тодорхой ялгарч байдаг.

Хялбархан эгшиг аяыг хоолойн нугалаагаар урлан чимэглэж 16 хувийн эгшгээр төгсгөлийн чимэглэл хийж, өгүүлбэр хоорондын зогсцод байн байн тэгш хэмтэй амдуулан дуулах нь үндсэн эгшгийг улам ч хээнцэр урлан чимэглэдэг. Барга, буриад уртын дуунд зарим томоохон зохиомж бүтэцтэй дуу байдгийг эс тооцвол бүхэлдээ бадрангуй, далайцтай бүтээл цөөн, ихэнх дууны цар хүрээ нь цахар, үзэмчнээс харьцангуй бага байдаг.

Барга уртын дуунд үгийг үеэр задруулан, аялах явцад органикаар шүтэлцүүлэн дуулах нь өвөрмөц бөгөөд олонх нутгийн уртын дуунд үгийг аялгууны зарим хэсэгт бүхлээр дуулж, залгаад аяа уртлуулан дуулахаас эрс өөр байдаг. Энэ тухай судлаач Батад Равтан: “Барга уртын дууг дуулахад үгийг үеэр салган задгайруулан дуулдаг онцлогтой. Тэгэхдээ олонх үе бүхэн нь нэг нэг

цохилгод дуулагдаж, зарим нэг үеийг урт аяар сунжруулан дуулна” (Равтан, 2007: 66) гэжээ.

2. Цахар, үзэмчний уртын дууны аялгууны хэв намбын шиж чанар

Цахар, үзэмчний уртын дуу нь ерөнхий онцлог нь уянгалаг эгшиглэнтэй, аялгууны найрсал зохирол сайнаараа алдартай. Энэ онцлог нь ихэвчлэн аялгууг үелзүүн, уртаггал уужим гоёмсог, аялгууны сэтгэлгээ төгс гүнзгий, яруу, уран нарийн, сэтгэлийн аяс тодорхой илэрнэ. Энэ нь монгол уртын дууны үндсэн хэв намба юм. Гол онцлогийг авч үзвэл,

Жийрэг үгээр байн байн уртлуулан эгшиглүүлэх ба дууны үг цөөн, аялгуу урт, уртаггалын хөгжил нь зохиомжийг нэн баялаг болгожээ. Аялгууны чимэглэлийн дэс дараа, хөгжингүй, үндсэн аясын чимэглэл нь баялаг. Эдгээр нь тухайн нутгийн хөгжмийн эрхэмсэг ерөнхий хэв намбын суурь нь юм. Шаталсан эгшгийн аялгуугаар дэлгэрүүлэх буюу доод өнгөнөөс аажмаар өгсүүлэн уртаггадаг. Энэ нь уртын дууны аялгууг шатлан дэлгэрүүлж хөгжүүлдэг чанарт түшиглэсэн эгшиг дэлгэрүүлэх үндсэн онцлог юм. Ямагт өгсөн үсэрч эргэн уртаггаж, огцом өрнөх урамсын хувиралтыг чадамгай ашигладаг. Бусад бүс нутагт уруудан үсрэх том эргэлтийг олонтой хэрэглэдэг.

Аялгууны уртаггалын аяын цараа уужим. Зарим дуунд аялгуунд 15 градусыг давж байна. Энэ нь илтгэх чанарыг дахин нэмэгдүүлж, дуулах ур эрдмээ чөлөөтэй илэрхийлэхэд уудам зай олгодог. Энэ талаар эрдэмтэн С.Баянжаргал: “Шилийн голын дууны өрнөлийн хэсэгт уг аажмаас наймцын өргөлттэй бөгөөд тэнгэр өнгийн шуранхайгаар дуулж илтгэх шаардлагатай” (Баянжаргал, 2000: 51) гэж бичиж байсан юм. Аялгууны том хэмжээний уртаггал аяыг урт амьсгалт томоохон өгүүлдүүдийг багтаан дуулдаг тул амьсгал уужим, айзам удаан чанарыг илтгэж байна.

Тав. Дуулах ур мэргэжлийн үндсэн шинж чанар

1. Барга, Буриадын уртын дууны дуулах ур мэргэжлийн үндсэн шинж чанар

Барга, буриадын уртын дуучид дуугаа дуулах байдал нь амьсгаа дүүрэн, хангалттай, өндөр эгшиглэгээ нь эрэмгий хүчтэй, чимэглэлийг далайцтай хийдгээрээ омголон, сүр жавхаатай хэв намбыг бүрэлдүүлжээ. Тавхай, Буяндэлгэр, Нүмаа зэрэг дуучид бол том төлөөлөгчид мөн.

Барга, буриадын дуучид торгон, зөөлөн нугалааг өргөн хэрэглэж, хүчиллэг байранд онцгой товойлгодог. Өндөр өнгөнд найруулгыг байнга хэрэглэж цээлхэн эгшгийг дуурьсуулж, хаялгыг түгээмэл хэрэглэж үсрэн уруудах хэлбэрийг тодорхой сонсгоно. Тиймээс “Хөлөн буйрын уртын дуу бол нугалаа чимэглэлээ тагнайн цохилгоор гаргадгаас ганган дэгжин хаялга цохилготой, цар нь маш өргөн бөгөөд аялгуу нь уужим тэнэгэр байдаг” (Буяндэлгэр, 1984: 10 сар). Хоолойн нугалаагаар цайруулах нийлэг мэргэжлийг хэрэглэж дуу хөгжмийн чадамжийг чангаруулдаг. Эдгээр нь тухайн бүс нутгийн өнгө онцлогийг бүрдүүлэхэд чухал үйлдэл үзүүлжээ.

2. Цахар, үзэмчний уртын дууны дуулах ур мэргэжлийн үндсэн шинж чанар

Цахар нь Шилийн голын тал нутагт Юань улсын үеэс удамшсан ордны ба алдарт дуучид олон байжээ. Хааны ордон, чуулган Да, хошуу ван, ноёдын ордны

урлагийн бүлгэм хамтлагийн сайн дуучид төрийн баяр ёслол, тахилга тайлга, найр хурим зэрэгт тодорхой байр суурьтай дуулж хөгжимддөг байв. Тэд олон газар, овог аймгийн дуучнаас ордонд шалгарч сонгогдон ирдэг байсан тул нэр цуутай дуучид байсан юм. Харин ардын дуучид жирийн малчин ардын дундаас тодрон гарсан соёл урлагийг уламжлах гол хүчин байв. Тэд тооны хувьд олон боловч тус тусын орон нутагтаа тархай бутархай амьдарч, өөр өөрсдийн хэв намба, хоолойн чадлаараа ялгардаг байжээ. Орчин үеийн алдарт дуучин Дамдин, Лхажав, Мээдэг нар бол том төлөөлөгч мөн. Цахар, үзэмчний дуучид дуулах ур чадварын хувьд, өндөр өнгөнд олонтой шургуулж, цайруулж, шургуулах нийлэг чадавхыг чухалчилдаг. Өндөр эгшигт уран чадамгай шургуулж, нугалаа чимгийг далайцтай хийж дуулна. Дууны үндсэн эгшгийг эрүү, тагнайн нугалааг зөөлөн, аясаар нь гоёмсог чимэглэж, аялгуу хөгийг нийцтэй, эвлэг болгоно. Хос буюу олон эгшгээр олонтоо өгсөн цацаж, өндөр өнгөнд үндсэн аялгууг урлан чимэглэдэг. Уруудуулахдаа уран цацалгаатай амдуулах, өгсүүлэн цацаж уруудуулан хаях зэрэг ур чадвартай. Тагнайн нугалаа, цацлагыг хамжуулах байдлаар өндөр өнгөнд шургуулах нь нийтдэг ур чадвар. Торгон зөөлөн хоолойн нугалааг түгээмэл хэрэглэдэг боловч Барга, буриадынхаас илүү зөөлөн байдаг нь дууг уран яруу уянгалаг болгох хөгжмийн сэтгэлгээг харуулна.

Дүгнэлт

Монгол уртын дуу нь хамтын онцлог, нийтлэг шинж олонтой боловч нутаг, нутгийн өнгө онцлогоороо ялгарч байдаг. Барга, буриадын болон цахар, үзэмчний уртын дуу нь ая аялгуу, хөг өнгө, хэв намба, дуулах арга барил гэх мэт олон талаар нийтлэг шинжтэй боловч овог аймаг, бүс нутаг, зан үйлийн зориулалт зэрэг ялгаатай, өөр өөрсдийн онцлог шинжээрээ тодрон ялгарч байна. Барга, буриадын уртын дуу чадал хүч илэрсэн ерөнхий хэв намбатай байхад, цахар, үзэмчний хувьд ээвэргүү зөөлөн, яруу уянгалаг байдлаараа алдаршсан байна.

Ном зүй

Равтан, Б. (2007). Барга ардын уртын дууны тухай өгүүлэх нь // *Улалж нарын найруулсан: “Монгол уртын дууны олон улсын ярилцааны тавцангийн шилдэг өгүүллийн түүвэр”*, анхны хэвлэл, ӨМӨЗО: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Ravtan, B. Barga ardiin urtiin duuny tukhai ögüülekh ni// Mongol urtiin duuny olon ulsiin yariltsaany tavtsangyn shildeg ögüüllin tüüver, Övör mongolyn ardyn khevleliin khoroo. 2007.]

Баянжаргал, С. (2000). *Монгол уртын дууны учир зүй*, ӨМӨЗО: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Bayanjargal, S. Mongol urtiin duunii uchir züi, Övör mongoliin ardiin khevleliin khoroo. 2000.]

Буяндэлгэр. (1984). Хөлөн буйрын ардын дуу, ӨМӨЗО: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Buyndelger. Hulunbuiriin ardiin duu, Övör mongoliin ardiin khevleliin khoroo: 1984.]

Лю Хун Жиу, (1981). Монгол үндэстний ардын дууны хөгийн хэлбэрийн тухай анхны шинжилгээ, ӨМӨЗО: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Mongol undestni ardiin khevleliin khoroo. 1981.]

Өлзийбаяр, Ш. (2008). Цахар Шилийн голын монгол уртын дууны бүс нутгийн өнгө онцлог // *Улаанхад дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*, 2008

оны 5 дугаар хугацаа, 43 дугаар нүүр. БНХАУ: Улаанхад. [Ölziibayar, Sh. Tsakhar shiliin goliin mongol urtiin duunii büs nutgiin öngö ontslog, Ulaankhad. 2008.]

Өлзийбаяр, Ш. (2011). Дундад улсын монгол ардын уртын дууны бүс нутгийн өнгө онцлог, //Дундад улс-Монгол үндэстний ардын дуу урлагийн судалгааны хурлын өгүүллийн эмхэтгэл, уртын дуу, ӨМӨЗО: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.[Ölziibayar, Sh. Dundad ulsiin mongol ardiin urtiin duunii nutgiin öngö ontslog, Övör mongolyn ardiin khevleliin khoroo. 2011.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>